

“Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг ” хэлэлцүүлгээс

гарсан зөвлөмж

Улаанбаатар хот

2024.06.04

Нэг. Цахим хөгжил харилцаа холбооны яам, Гадаад харилцааны яам Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яам:

- Цахим худалдааны тухай хууль боловсруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3.10-т заасан “цахим засгийн хороо (зөвлөл)”-ны дэргэд “цахим худалдааны дэд хороо” байгуулж, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах;
- Монгол Улсын цахим худалдааны хөгжлийн богино, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах;
- Монгол Улсын цахим худалдааны хөгжлийн судалгаа хийх;
- Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, төр хувийн хэвшил олон нийтэд нээлттэй байлгах;
- Цахим худалдаа, мэдээллийн технологийн үйлчилгээ эрхлэгчдийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа болон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;
- Цахим худалдааны тухай эрх зүйн баримт бичгийг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн, боловсруулах;
- Цахим худалдааны хэрэглэгчийн кибер аюулгүй байдлыг хангах, эрх зүйн орчныг сайжруулах

Хоёр. Монголбанк, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, И-Монгол академи УТҮГ, Хил хамгаалах ерөнхий газар:

- Олон улсын зах зээлд борлуулагдсан бараа бүтээгдэхүүний орлогыг банкны дансанд хүлээн авах хялбар, шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд Үндэстэн дамнасан санхүүгийн технологийн компаниудтай хамтран ажиллах, үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх банк санхүүгийн байгууллагад туслалцаа үзүүлэх;
- Монгол Улсын хил дамнасан цахим худалдаанд тэргүүлэх чиглэлтэй улс орнуудын банк санхүүгийн байгууллага, финтекийн оролцоог нэмэгдүүлэх;
- Цахим худалдааны тухай хуулийг боловсруулах, мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.15, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.24 дэх заалтад тус тус өөрчлөлт оруулсны дараа “Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулах төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах;

- Цахим худалдааны үйл ажиллагаанд дахь цахим технологийг И-Монгол академи УТҮГ-тай хамтран хэрэгжүүлж, хэрэглэгчдэд шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг бий болгох;
- Хил дамнасан цахим худалдааг хөнгөвчлөх, хилийн боомтын үйл ажиллагааг хялбаршуулах, хилийн авто замын боомтоор нэвтрүүлэх улс хоорондын шуудан илгээмжийг ачсан тээврийн хэрэгслийг шуурхай нэвтрүүлэх;
- Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн хяналтын бүс байгуулах, Улаанбаатар хот болон дагуул хотын нутаг дэвсгэрт газар шуудангийн илгээмжийн терминал байгуулахад төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж ажиллах;
- Цахим худалдааны платформуудад гаалийн болон бусад татвар, хураамжийг хураан авах, гаалийн байгууллагын цахим төлбөрийн системтэй холбох, үйлчилгээ, борлуулалтад и-баримт олгох асуудлыг шийдвэрлэх;
- Шуудангийн сүлжээгээр дамжин хил дамнасан цахим худалдаа буюу гадаад орнуудаас цахим худалдаагаар захиалагдсан импортлогдсон шуудангийн илгээмжид тавигдах татварын зохицуулалтыг тодорхой, ойлгомжтой болгож, иргэдэд мэдээлэх

Гурав. Зохицуулах байгууллага (ХХЗХ):

- Цахим худалдаа, программ хөгжүүлэгч болон шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн харилцан хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сургалт зөвлөгөөн хэлэлцүүлгийг зохион байгуулах;
- Шуудангийн салбарын зохицуулалтын бодлогод цахим худалдаа эрхлэгчдийн хооронд өрсөлдөөний бус нэгдэн нийлэлт, харилцан холболтын зарчмыг баримтлах;
- Шуудан, илгээмж хүргэлтийн үйлчилгээнд дундын хаягийн нэгдсэн систем ашиглах боломжийг төр, хувийн хэвшилтэй хамтран бүрдүүлэх;
- Хэрэглэгчдийн боловсролд зориулсан хэвлэмэл болон аудио, видео контентыг бэлтгэн гаргах, олон нийтэд сурталчлан таниулах;
- Шуудангийн нэгдсэн кодыг барилга байгууламжаар оноож, мэдээллийн системийг сайжруулах

Дөрөв. Цахим худалдааны үйлчилгээ эрхлэгч, программ хангамж хөгжүүлэгчид, шуудангийн үйлчилгээ эрхлэгчид:

- Цахим худалдаа эрхлэгчдийн холбоо төрийн бус байгууллага байгуулан төрийн байгууллагатай хамтран ажиллах, богино болон дунд хугацааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Цахим худалдааны үйлчилгээний нөхцөлийг /хэрэглэгчийн гомдол, буцаалт/ хэрэглэгчдэд энгийн ойлгомжтой байлгах, олон нийтэд сурталчлах;

- Цахим худалдааны вэб сайт, аппликейшнийг ХХЗХ-нд бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулж байгаа хаяг, байршлын мэдээллийг тодорхой байлгах, хаягийн өөрчлөлтийг мэдээлж байх;
- Цахим худалдааны вэб сайт, аппликейшн нь хэрэглэгч ашиглахад энгийн, оновчтой цэстэй, хайлт хийх өргөн боломжтой (барааны бичвэр, зураг, дуу хоолой гэх мэт) байхаар хөгжүүлэх;
- Төлбөр тооцооны найдвартай, аюулгүй байдлыг хангах; (Two-factor authentication 2FA)
- Шуудангийн ухаалаг хайрцгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Шуудан илгээмж хүргэлтийн үйлчилгээнд технологийн дэвшлийг ашиглах
- Хүргэлтийн үйлчилгээний үнэ тарифыг хүргэлтийн хугацаанаас хамаарсан; ялгавартай тарифыг хэрэглэгчдэд санал болгох, нийтэд мэдээлэх, сурталчлах;
- Шуудангийн үйлчилгээнд байгаль, хүрээлэн буй орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, ашиглах
- Шуудангийн хүргэлтийн үйлчилгээг хурдан шуурхай болгох

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО